



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/074/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор Д.Оюун-Эрдэнэ
Утас: 88916603 Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2026.02.25 № 2/127

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буулгах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>171,124,701.36</u>	<u>186,665,821.04</u>
33	АВЛАГА	774,365.20	905,853.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	774,365.20	675,853.75
335	Бусад авлага	-	230,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	230,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	170,350,336.16	185,759,967.29
351	Түүхий эд материал	12,509,000.00	31,001,500.00
35110	Тусгай зориулалттай материал	12,509,000.00	31,001,500.00
354	Хангамжийн материал	146,867,846.87	143,784,978.00
35410	Бичиг хэргийн материал	3,941,975.00	3,042,950.00
35420	Аж ахуйн материал	56,918,871.87	24,361,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	100,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	450,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	6,775,000.00
35470	Бусад хангамжийн материал	85,457,000.00	109,606,028.00
35600	Мал амьтад	10,973,489.29	10,973,489.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,269,159,246.48</u>	<u>3,256,120,737.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,269,159,246.48	3,256,120,737.61
392	Биет хөрөнгө	2,921,631,353.98	2,908,592,845.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,082,559,477.24	3,132,676,554.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,010,916,157.60)	(1,160,048,230.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	378,457,777.67	418,857,777.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(183,921,213.01)	(143,696,990.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	419,164,238.93	449,862,047.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(228,867,340.54)	(215,978,256.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,427,642.72	81,319,342.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,537,590.13)	(48,242,792.29)
39209	Зам, гүүрийн байгууламж	209,800,000.00	209,800,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(83,783,999.88)	(90,077,999.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	587,855,891.40	552,468,170.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(271,924,372.82)	(278,663,778.16)
39217	Ном	317,000.00	317,000.00
393	Биет бус хөрөнгө	347,527,892.50	347,527,892.50
39301	Програм хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.00)	(850,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	347,527,892.50	347,527,892.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,440,283,947.84</u>	<u>3,442,786,558.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>871,122.65</u>	<u>8,081,836.14</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	871,122.65	8,081,836.14
413	Өглөг	871,122.65	8,081,836.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	821,122.65	811,244.14

Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4136	Бусад өглөг	50,000.00	7,270,592.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,270,592.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	50,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,439,412,825.19	3,434,704,722.51
51	Засгийн газрын хувь оролцоо	3,439,412,825.19	3,434,704,722.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	513,984,711.00	513,984,711.00
51101	Өмч: - төрийн	513,984,711.00	513,984,711.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,733,525,160.40	2,728,817,057.72
51210	Өмнөх үеийн үр дүн	2,733,525,160.40	2,733,525,160.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,708,102.68)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,902,953.79	191,902,953.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,440,283,947.84	3,442,786,558.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,960,711,370.54	1,388,271,954.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	938,420,086.54	348,430,254.00
120	Нийтлэг татварын бус орлого	938,420,086.54	348,430,254.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	938,420,086.54	348,430,254.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,835,880.00	15,718,181.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	933,584,206.54	332,712,073.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,291,284.00	1,039,841,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,456,584.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,262,014.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,194,570.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	990,834,700.00	1,039,841,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	990,834,700.00	1,039,841,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,251,978,476.16	1,373,370,056.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,251,978,476.16	1,373,370,056.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,221,856,527.69	1,346,997,126.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,167,048.51	664,252,663.00
210101	Үндсэн цалин	389,027,999.51	421,173,780.00
210102	Нэмэгдэл	198,804,299.00	234,335,498.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,370,000.00	00.00
210104	Урамшуулал	23,964,750.00	7,797,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	946,385.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,567,555.89	81,565,756.39
210201	Тэтгэврийн даатгал	52,164,442.55	56,137,763.73
210202	Тэтгэмжийн даатгал	6,187,050.67	6,610,724.78



Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,093,526.90	3,293,437.49
210204	Ажилгүйдлийн даатгал	2,812,718.28	3,498,850.95
210205	Эрүүл мэндийн даатгал	11,309,817.49	12,024,979.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,728,928.44	54,563,860.00
210301	Гэрэл, цахилгаан	5,655,301.44	8,012,650.00
210302	Түлш, халаалт	41,073,627.00	44,551,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	153,519,271.00	185,800,436.87
210401	Бичиг хэрэг	939,600.00	5,497,100.00
210402	Тээвэр, шатахуун	41,888,251.00	33,595,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,571,900.00	3,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,850,000.00	24,843,880.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,269,520.00	32,954,933.69
210408	Бараа материал акталсны зардал	00.00	85,509,363.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,687,000.00	6,182,450.00
210604	Урсгал засвар	2,687,000.00	6,182,450.00
2107	Томилолт, зочны зардал	6,806,000.00	11,790,000.00
210702	Дотоод албан томилолт	6,806,000.00	11,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,592,526.00	12,331,955.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,985,662.00	8,823,170.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,400.00	545,179.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	735,168.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,401,000.00	1,818,000.00
210807	Газрын төлбөр	527,296.00	458,606.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,788,197.85	330,510,004.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,771,128.00	19,210,551.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,597,400.00	520,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	252,419,669.85	310,779,453.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,121,948.47	26,372,930.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,570,996.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	130,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,790,996.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,550,952.47	26,372,930.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,550,952.47	26,071,745.55
213404	Хөрөнгийн	00.00	301,185.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	708,732,894.38	14,901,897.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	19,610,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	19,610,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(19,610,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	708,732,894.38	(4,708,102.68)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,027,642,044.00</u>	<u>1,055,559,881.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,835,880.00	15,718,181.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,835,880.00	15,718,181.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,835,880.00	15,718,181.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,835,880.00	15,718,181.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,806,164.00	1,039,841,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,456,584.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,262,014.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,194,570.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	990,834,700.00	1,039,841,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	990,834,700.00	1,039,841,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	514,880.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	514,880.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>916,872,244.00</u>	<u>963,659,881.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,872,244.00	963,659,881.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,974,417.53	936,286,950.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	618,539,242.95	663,964,729.84
210101	Үндсэн цалин	348,536,620.95	376,363,606.72
210102	Нэмэгдэл	236,865,116.00	260,692,419.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,470,000.00	-
210104	Урамшуулал	24,667,506.00	25,962,319.12
210105	Гэрээт ажлын хөлс	-	946,385.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,471,999.14	83,189,466.61
210201	Тэтгэврийн даатгал	52,680,999.16	56,569,547.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,197,699.98	6,654,637.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,098,900.00	3,327,525.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3,098,900.00	3,327,421.45
210205	Эрүүл мэндийн даатгал	12,395,500.00	13,310,333.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,056,088.44	55,399,760.00
210301	Гэрэл, цахилгаан	6,532,461.44	8,848,550.00
210302	Түлш, халаалт	41,523,627.00	44,551,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,478,351.00	54,593,400.00
210401	Бичиг хэрэг	3,355,800.00	2,501,400.00
210402	Тээвэр, шатахуун	22,813,800.00	21,272,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,408,900.00	2,764,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,899,851.00	25,699,880.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,058,312,543.45	-	1,764,200,208.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	1,058,312,543.45	-	1,764,200,208.24
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	966,729,722.57	-	66,729,722.57
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	2,733,525,160.40	-	3,439,412,825.19
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	2,733,525,160.40	-	3,439,412,825.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	2,733,525,160.40	-	3,439,412,825.19
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,708,102.68)	-	(4,708,102.68)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	513,984,711.00	191,902,953.79	2,728,817,057.72	-	3,434,704,722.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,073,721,500.00	1,015,402,784.40	58,318,715.60	94.6
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,073,721,500.00	1,013,769,954.40	59,951,545.60	94.4
Орон нутгийн төсвөөс	1,073,721,500.00	1,013,769,954.40	59,951,545.60	94.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,632,830.00	(1,632,830.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,632,830.00	(1,632,830.00)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,073,721,500.00	1,015,402,784.45	57,646,115.55	94.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,073,721,500.00	1,015,402,784.45	57,646,115.55	94.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,221,500.00	1,014,402,784.45	55,146,115.55	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,528,900.00	663,018,344.84	2,510,555.16	99.6
Үндсэн цалин	376,369,600.00	376,363,606.72	5,993.28	100.0
Нэмэгдэл	260,692,600.00	260,692,419.00	181.00	100.0



Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урамшуулал	28,466,700.00	25,962,319.12	2,504,380.88	91.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,191,200.00	83,189,466.61	2,033.39	100.0
Тэтгэврийн даатгал	56,569,900.00	56,569,547.86	352.14	100.0
Тэтгэмжийн даатгал	6,655,100.00	6,654,637.81	462.19	100.0
ҮОМШӨ-ний даатгал	3,327,700.00	3,327,525.99	174.01	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,327,700.00	3,327,421.45	278.55	100.0
Эрүүл мэндийн даатгал	13,310,600.00	13,310,333.50	266.50	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,591,800.00	55,399,760.00	10,192,040.00	84.5
Гэрэл, цахилгаан	10,500,000.00	8,848,550.00	1,651,450.00	84.3
Түлш, халаалт	53,091,800.00	44,551,210.00	8,540,590.00	83.9
Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	59,694,600.00	52,873,770.00	6,820,830.00	88.6
Бичиг хэрэг	4,500,000.00	2,501,400.00	1,998,600.00	55.6
Тээвэр, шатахуун	23,600,000.00	20,505,490.00	3,094,510.00	86.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,694,600.00	2,614,000.00	80,600.00	97.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,900,000.00	25,699,880.00	200,120.00	99.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	1,553,000.00	1,447,000.00	51.8
Нормативт зардал	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	41,000,000.00	40,999,450.00	550.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
Урсгал засвар	20,000,000.00	19,999,450.00	550.00	100.0
Томилолт, зочны зардал	21,500,000.00	12,020,000.00	9,480,000.00	55.9
Дотоод албан томилолт	21,500,000.00	12,020,000.00	9,480,000.00	55.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,810,000.00	69,606,955.00	8,203,045.00	89.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,500,000.00	66,098,170.00	5,401,830.00	92.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00	800,000.00	0.0
Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	545,179.00	4,821.00	99.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	360,000.00	187,000.00	173,000.00	51.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,500,000.00	1,818,000.00	1,682,000.00	51.9
Газрын төлбөр	600,000.00	458,606.00	141,394.00	76.4
Бараа үйлчилгээний бусад зардал	54,905,000.00	37,295,038.00	17,609,962.00	67.9
Бараа үйлчилгээний бусад зардал	50,905,000.00	34,448,838.00	16,456,162.00	67.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	2,846,200.00	1,153,800.00	71.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.00	1,000,000.00	2,500,000.00	28.6
Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	1,000,000.00	2,500,000.00	28.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,500,000.00	1,000,000.00	2,500,000.00	28.6

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,784,166.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,784,166.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,577,662.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,206,504.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,784,166.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,784,166.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,784,166.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	946,385.00
210105	Гэрээт ажлын хөлс	946,385.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,719,630.00
210402	Тээвэр, шатахуун	767,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	802,500.00
2106	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,458,000.00
210604	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,458,000.00
2108	Бараа үйлчилгээний бусад зардал	1,660,151.00
210801	Бараа үйлчилгээний бусад зардал	1,660,151.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянговь сумын Засаг даргын Тамгын газар нь орчин үеийн тэргүүний техник хэрэгсэл нэвтрүүлсэн өндөр боловсрол, мэргэжил, туршлага, дадлагатай хүн, хүний нөөцөөр хамгийн оновчтой хэрэгжих магадлал, тооцоо өндөртэй зорилго зорилтыг тодорхойлж цомхон чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг байгууллага иргэдэд хөнгөн шуурхай хүртээмжтэй үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024.12.25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2025.01.03-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаал (Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам)
- Сангийн сайдын 2025.06.02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянговь сумын Засаг даргын Тамгын газар нь дотоод аудитын нэгж байгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газар хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн загвараар бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн СТСХ-ээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичиг”-ийг санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянговь сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмууд, УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,502.6 мянган төгрөг буюу 0.07 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	171,124.7	186,665.8	15,541.1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	-
Авлага	774.4	905.9	131.5
Бараа материал	170,350.3	185,760.0	15,409.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,269,159.2	3,256,120.7	(13,038.5)
Үндсэн хөрөнгө	5,102,959.9	5,193,678.8	90,718.9
Хуримтлагдсан элэгдэл	(1,833,800.7)	(1,937,558.0)	(103,757.4)
Нийт хөрөнгө	3,440,283.9	3,442,786.6	2,502.6
Өр төлбөр	871.1	8,081.8	7,210.7
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	3,439,412.8	3,434,704.7	(4,708.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,440,283.9	3,442,786.6	2,502.6

Дээрх хүснэгтээс харахад Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 185,760.0 мянган төгрөг болж өмнөх оноос 15,409.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 79,180.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 116,271.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 85,522.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 85,509.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан, сумын онцгой комиссын шийдвэрээр 9,010.0 төгрөгөөр өвс тэжээлийн үнийг хямдруулж бууруулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,193,678.8 мянган төгрөг болж 90,718.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 26,900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж орлогод авсан, 270,840.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймаг болон сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор хүлээн авч бүртгэлд тусгасан, 152,022.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан, 55,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Дүн	Тушаал шийдвэр
1	Авто-тээврийн хэрэгсэл	119,000,000.00	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025.08.26-ны өдрийн 8/52 дугаар тогтоол
2	Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,750,000.00	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025.03.11-ний өдрийн "үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай" 5/05 дугаар тогтоол
3	Бусад үндсэн хөрөнгө	18,431,615.00	
4	Машин тоног төхөөрөмж(компьютер)	21,700,000.00	Баянговь сумын ИТХ-ын хуралдааны 2025.09.10-ны өдрийн 4/02 дугаар тогтоол

5	Барилга, байгууламж, орон сууц	57,806,077.00	Баянговь сумын ИТХ-ын хуралдааны 2025.12.18-ны өдрийн Б/01 дугаар тогтоол
6	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,900,000.00	
7	Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,253,253.00	
Дүн		270,840,945.00	

Тайлбар: Авто-тээврийн хэрэгслийн үнэнд сумын ЗДТГ-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ /81518/-ний зардлаас 65,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 54,000.0 мянган төгрөг зарцуулагдсан болно.

Тайлант онд 8,081.8 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна. Үүнд:

- Тээвэр шатахууны өглөг 2,328.1 мянган төгрөг – Энэ нь жилийн эцсийн хүн ам, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын шатахууны зардлын өглөг бөгөөд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулагдахаар 2025.12.04-ний өдрийн А/105 дугаар захирамж гарсан бөгөөд тус зардлын эрх нээгдээгүйгээс төлж чадаагүй өртэй гарсан байна. Тайлант онд тээвэр, шатахууны зардалд 23,600.0 мянган төгрөг төсөвлөгдөж, 20,505.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Байгууллагад өгөх өр 1,710.0 мянган төгрөг – Энэ нь Засаг даргын 2024 оны А/106 дугаар захирамжаар батлагдсан “Оны шилдэг 9 алдартан шалгаруулах журам”-ын дагуу шагнал урамшууллын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахаар 2025.12.22-ны өдрийн А/112 дугаар захирамжийн дагуу бэлтгэсэн зүйлстэй холбоотой өр байна.
- Интернэт, цахилгаан холбооны үйлчилгээний төлбөрийн өглөг 636.0 мянган төгрөг - энэ нь 10, 11, 12 дугаар сарын үйлчилгээний төлбөр бөгөөд тус зардлын зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотойгоор өр үүссэн байна.
- Бичиг хэргийн зардлын өглөг 2,353.0 мянган төгрөг – Тус зардлын 502.5 мянган төгрөг нь жилийн эцсийн хүн ам, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллоготой холбоотой хэвлэмэл маягт, бичиг хэргийн материалын үнэ бөгөөд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулах захирамжтай, үлдсэн 1,850.5 мянган төгрөг нь бичиг хэргийн зардалтай холбоотой байна. Эдгээр зардлуудын зарцуулах эрхийг 10 дугаар сараас хойш нээж өгөөгүйтэй холбоотойгоор үүссэн өр байна.
- ХХОАТ-ын өр 175.1 мянган төгрөг – Энэ нь ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, тордолт хийх ажлын гэрээтэй холбоотой төлөх өр байна.
- Ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, тордолт хийх ажлын гэрээний өглөг - 879.6 мянган төгрөг – тус зардал нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас төлөгдөх, 7 ба 8 дугаар сард гэрээгээр ажил гүйцэтгүүлсэнтэй холбоотой зардлыг өглөг бөгөөд тус зардлын зарцуулах эрх дээр 7 дугаар сараас хойш санхүүжилт нь орж ирээгүй хаагдсантай холбоотой.

Дээрх өр төлбөрүүдийг бэлтгэн нийлүүлэгч, байгууллага тус бүрээр тооцоо нийлж, актаар баталгаажуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,434,704.7 мянган төгрөг болж 4,708.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Аcolous санхүүгийн программыг 2018 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд 250.0 мянган төгрөгийн

өртөгтэй, 250.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, ашиглалтын байдал хэвийн. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд программын үйлчилгээний төлбөрт 800.0 мянган төгрөг урсгал зардлын төсвөөс зарцуулсан байна. Мөн төрийн сангийн сүлжээний программыг 2015 оноос хойш ашиглаж байгаа ба санхүүгийн бүртгэл тайланд 600.0 мянган төгрөгийн өртөгтэй, 600.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, ашиглалтын байдал хэвийн байна

Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тус байгууллага нь 576,949 мкв талбай бүхий нийт 30 газар эзэмших эрхийн гэрчилгээтэй. Үүнээс, 4 газар эзэмших эрхийн гэрээний хугацаа дууссан байна.

Дээрх газрууд нь үндсэн хөрөнгийн бүртгэл болон цахим санд (egazar.gov.mn) бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,086,644.5 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 31,075.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн төсвөөс 1,117,719.7 мянган төгрөгөөр санхүүжихээр баталсан байна.

Тайлант онд Баянговь сумын ИТХ-ын хуралдааны 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 21/01 дугаар тогтоолоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 43,998.2 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс 1,073,721.5 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөвт тодотгол хийж өөрчилсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,039,841.7 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,632.8 мянган төгрөг нийт 1,041,474.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,015,402.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 26,071.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,073,721.5	1,015,402.8	58,318.7	94.6
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	743,885.6	711,674.4	32,211.2	95.7
1.2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	182,130.9	178,279.6	3,851.3	97.9

1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	3,500.0	1,000.0	2,500.0	28.6
1.4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0	27,285.9	12,714.2	68.2
1.5	81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	68,300.0	65,000.0	3,300.0	95.2
1.6	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	10,905.0	7,163.0	3,742.0	65.7
1.7	82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал	25,000.0	24,999.9	0.1	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас шагналын 8,000.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс хүн ам, орон сууцны тооллого, мал тооллогын зардалд 2,577.7 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 3,507.7 мянган төгрөг, нийт 14,085.4 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, үлдэгдэл 301.2 мянган төгрөгийг орон нутагт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

1. Байгууллагын орон тооны цомхотгол: Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн “Бүтэц орон тоо, цалингийн сан батлах тухай” А/01 дугаар тушаалаар удирдах 8, гүйцэтгэх 8, үйлчлэх 8, гэрээт -3, нийт 27 орон тоотой ажиллахаар баталсан, ба тайлант онд 24 орон тоотойгоор ажилласан. 9 дүгээр сараас 1 гэрээт ажилтныг цалингийн сангийн төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар ажлаас чөлөөлсөн байна.

2. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал: Тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн 2 арга хэмжээ төлөвлөж зохион байгуулсан байна. Төрийн албан хаагч, иргэд, татвар төлөгчдөд зориулж “Татвар төлөгчдийн өдөрлөгт зориулсан сургалт семинар”, малчид төлчдөд зориулж “Малчид төлчдийн зөвлөгөөн” зохион байгуулж хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 1,675.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,638.0 мянган төгрөг, нийт 8,313.0 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 53,091.8 мянга, гэрэл цахилгааны зардалд 10,500.0 мянга, тээвэр шатахууны зардалд ЗДТГ-т 20,000.0, багуудад 3,600.0 мянган төгрөг батлагдаж “Бэст хонгор” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “ЭБЦТС Өвөрхангай дахь салбартай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээ, “Ник” ХХК-тай шатах тослох материал нийлүүлэх гэрээг байгуулж ажилласан байна.

Гүйцэтгэлээр цахилгааны зардалд 8,848.6 мянган төгрөг, түлш халаалтын төлбөрт 44,551.2 мянган төгрөг, шатахууны зардалд 20,505.5 мянган төгрөг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын ЗДТГ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,073,721.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,737.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 25 гүйлгээний 1,186,897.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл бүрэн гүйцэт, бусад мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсар үеийн аудитаар иргэдтэй байгуулсан цахилгаан үүсгүүр /мотор/-1ш, хонины ноос хяргагч-1ш төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зөвлөмж өгсөн. Тус зөвлөмжийн дагуу гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, 1 гэрээ түрээслэгчийн хүсэлтээр цуцлагдсан байна.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бунчинсүрэн гүйцэтгэсэн ба аудитаар нийт 142,680.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 51 дугаартай албан бичиг ирүүлэн, санхүүгийн тайлангийн аудитын FAS системд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	135,600.0	4	135,600.0	100%
Төлбөрийн акт	1	80.0	1	80.0	100%
Зөвлөмж	1	7,000.0	1	7,000.0	100%
Нийт дүн	6	142,680.0	1	142,680.0	100%

Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө сэдэвт нийцлийн аудитаар өгсөн 10,000.0 мянган төгрөгийн албан шаардлагын үлдэгдэл 1,500.0 мянган төгрөгийг аудитын явцад нөхөн сэргээлтийн дансанд байршуулж, албан шаардлагыг биелүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----